

➤ БНХАУ-ЫН ДЭД ДАРГЫН АЙЛЧЛАЛ

➤ НААДМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

➤ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

IV НҮҮРТ



Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

МОНГОЛЫН ГУРВАН СУЛРАЛ

II НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2019.07.17, №2 (106)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.defacto.mn

МОНГОЛЫН ГУРВАН СУЛРАЛ



1

ХУУЛИЙН
ЗАСАГЛАЛ



2

ЧӨЛӨӨТ
ЗАХ ЗЭЭЛ



3

ШУДАРГА ЁС



Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

МОНГОЛЫН ГУРВАН СУЛРАЛ

Улс орон хөгжих буюу иргэд нь амар амгалан, аз жаргалтай амьдрахын тулд ардчилсан засаглал, чөлөөт зах зээл, шударга ёс гэсэн гурван тулгуур бат бэх бүрдсэн байх ёстой. Эдгээр тулгуураа Монгол улс хараат бус болсноосоо хойш 30 жилийн дотор ямар түвшинд бүрдүүлсэн, ямар асуудал, сорилт эдүгээ тулгараад байна вэ?

ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ

Өндөр хөгжсөн орнууд төр засгаа ардчилсан сонгуулиар байгуулж, дараагийн сонгуулиар нь сонгогчдоороо дүгнүүлж иржээ. Амалсан, ярьснаа биелүүлж ард түмний амьдралд эерэг өөрчлөлт авчирсан бол улс төрийн хүчин дахин сонгогдоногүй бол өөр нам төрийн эрхэнд гардаг.

Төрийн эрхэнд гарсан улс төрийн хүчин хууль журам гаргаж, түүнийг нь гүйцэтгэх засаглал нь үр өгөөжтэй биелүүлж, эдийн засаг хөгжих боломжийг хангадаг. Тэгвэл Монгол улсад энэхүү хууль журам гаргах ажил нь учир дутагдалтай, төрийн эрхэнд гарсан улс төрийн хүчин алсын хараагүй, сонгуулийн дөрвөн жилдээ тохируулж хууль батлаж ирлээ. Хамгийн тод жишээ нь сонгуулийн хуулийг сонгууль бүрийн өмнө өөрчилж байна.

Мөн хуулийг өөрсдийн явцуу эрх ашигт тааруулан гаргадаг болов. Жишээ нь нийтийн өмч хөрөнгийг завшсан этгээдэд тохируулж хөөн хэлэлцэх хугацаа нь дуусдаг хууль гаргаад хэргийг нь хаадаг болов. Төрийн

өмчийг хуулийн дагуу төрийн компани, банк байгуулж, дамжуулан завшсаны дараа элдэв нэртэй өршөөлийн хууль гаргаж мөнгө угаадаг болов. Ил тод байдлын гэх гоё нэртэй хууль гаргаж 2016 онд буюу монголын Засгийн газар түүхэндээ хамгийн их доллар зээлсний дараа алга болсон, нийтийн хөрөнгийг завшсан этгээдүүдийг өршөөж орхив. Энэ хуулиар эдийн засгаасаа том буюу 33 их наяд төгрөгийн хөрөнгө ил болж, эдүгээ Улаанбаатар хотын урд захаар хэдэн зуун барилга шахцалдуулан барьж байна.

Төрийн эрхийг ээлжлэн болон эвсэн барьж ирсэн хоёр том нам нь (МАН ба АН), санхүүжилтийн тайлангаа хэзээ ч үнэнээр нь гаргаж, хуулийн дагуу нийтэд ил тод болгож байгаагүй учир монголын төр засаг олигарх бүлэглэлийн гар хөл болов. Төр засгийн албан тушаалыг бараа шиг зардаг зуршил хэвийн үзэгдэл болжээ.

МОНГОЛД ХУУЛИЙН ЗАСАГЛАЛ СУЛ БАЙНА.

ЧӨЛӨӨТ ЗАХ ЗЭЭЛ

Хүн төрөлхтний түүхэнд зөвхөн чөлөөт зах зээл хамгийн их материаллаг баялагийг бүтээжээ. Чөлөөт зах зээл ажиллах суурь нөхцөл бол хувийн өмч юм. Коммунист нийгэм хувийн өмчийг хүлээн зөвшөөрдөггүй, зөвхөн нийтийн өмч байх ёстой гэж номлож байсан учир эдийн засаг бүрэн дампуурсан.

Коммунизмаас салснаас хойш Монгол улс хувийн өмч бүрдүүлэхийг оролдсоор байна. Зах зээлийн нийгэмд шилжин орсон 30 жилийн дотор монголчууд түүхэндээ хамгийн их хувийн өмчтэй боллоо. Эдийн засаг олон дахин томорч, иргэдийн амьдрал элбэг хангалуун болж, 10 жилээр урт наслах болов. Хүн ам 50 хувь, мал 250 хувиар өслөө.



Хүснэгт 1: Монгол улсын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд (1990 ба 2018 онд)

Үзүүлэлтүүд		1990 он	2018 он
ДНБ (тэрбум ам.доллар)		2.56	13.01
Нэг хүн ногдох ДНБ (ам.доллар)		1,172.443	4,103.697
Хүн амын тоо	Улсын хэмжээнд	2,153,466	3,238,479
	Нийслэлийн хэмжээнд	586,228	1,491,375
Автомашинны тоо	Улсын хэмжээнд	43,792	585,363
	Нийслэлийн хэмжээнд	13,578	401,725

Эх сурвалж: Дэлхийн Банк, Үндэсний Статистикийн Хороо

Нийтийн өмчит үйлдвэр аж ахуйн газрыг иргэддээ хувьчлав. Нэгдлийн өмчид байсан малыг малчдад нь хувьчлав. 30 жилд малын тоо 2.5 дахин өсч 66 сая болов. Гэхдээ хонь 2 дахин өсч 30 сая, ямаа 5.3 дахин өсч 27 сая болжээ. Орон сууцыг бас оршин сууж байсан өрхүүдэд нь хувьчлав. Газрыг иргэдэд хувьчлав. Иргэд бизнес чөлөөтэй эрхлэх болсноор өөрсдийн үйлдвэр, аж ахуйн газар, барилгатай болов.

Гэхдээ нийтийн өмч, ялангуяа газрыг орон нутаг, хотын засаг захиргаа, яамдын түшмэдүүд хувьдаа ихээхэн завшив. Хамгийн тод жишээ нь нийслэлийн урд уулын бүх амууд, Яармагийн дэнж, хотын төвийн газрын олголт.

**ХУУЛЬ БУСААР ХУВИЙН ӨМЧТЭЙ БОЛОХ
ҮЗЭГДЭЛ МОНГОЛД ХАВТГАЙРАВ.**

ШУДАРГА ЁС

Шударга ёсыг сахиулах нь шүүхийн үүрэг. Дээрх хоёр сорилт монголд шүүх засаглал бүрэн дампуурсныг батлаж байна. Шударга ёс гэдэг нь хууль зөрчсөн этгээдэд хариуцлага тооцохоос эхэлдэг. Монгол улсын шүүх авлига авсан төрийн ажилтнуудад хариуцлага хүлээлгэж чадахгүй байгаа учраас FATF буюу мөнгө угаах болон терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллага манай улсыг саарал жагсаалтад дахин оруулах гэж байна.

Шүүх нь нэг хүнээс буюу Ерөнхийлөгчөөс хэт хамааралтай болсон учир төрийн бүтцээ өөрчлөх гэж байна. Авлигадаа живсэн учир Монгол улс Үндсэн хуулиндаа энэ зуунд анхны өөрчлөлтөө хийх гэж байна. Өөрчлөлт хийсэн ч, хууль журмаа сахиулж чадахгүй бол энэ улс ядуурлаасаа салж чадахгүй.

Монголын ядуурал бол эдийн засгийн биш, улс төрийн хямралаас үүдэлтэй. Төр засгийн эрх мэдэлд очсон нь баяжих болсон учир иргэд төрийн албан

тушаалд очихын төлөө улс төржиж, намчирхан талцах нь хэвийн үзэгдэл болсон. Эхнэр нөхөр хоёр улс төржөөд салдаг болсон.

Энэ бүхэн бас хүний өөрийн хөгжилтэй холбоотой. Боловсролын одоо байгаа тогтолцоо нь хүүхдийг сайн хүн болгохоос илүү мэдлэгтэй болгохыг зорьдог. Монголчуудад хамтрах, нийтийн сонирхлоо хамгаалах эрмэлзлэл бага.

**МОНГОЛД ШУДАРГА БУС БАЙДАЛ
ДАВАМГАЙЛЖ БАЙНА.**

Товчоор, хөгжил, цэцэглэлийн гурван тулгуураа бэхжүүлж чадахгүй байгаа учир Монгол улс хүрсэн олон амжилтын үр шимээ ижил тэгш хүртэхгүй байгаа юм. Энэ гурван сулархай тулгуураа бэхжүүлэх нь монголчуудын өнөөгийн хамгийн том сорилт болчихлоо.

2019.07.17



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.07.14-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

БНХАУ-ЫН ДЭД ДАРГЫН АЙЛЧЛАЛ

Үйл явдлын товч:

Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн урилгаар БНХАУ-ын төрийн дэд дарга Ван Чишань 7-р сарын 10-12-ны хооронд айлчилж Ерөнхийлөгч Х.Баттулга, Ерөнхий сайд У.Хүрэлсүх, УИХ-ын дарга Г.Занданшатар нартай уулзлаа.

Дүгнэлт тайлбар:


Энэ айлчлал Монгол Хятадын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой, найрсаг харилцаа хамтын ажиллагааны гэрээний 25 жилийн ойтой давхцаж боллоо.

БНХАУ-ын Дэд дарга Ван Чишань хэлсэн үгэндээ, Монгол улсын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, Монголын ард түмний сонгосон хөгжлийн замыг БНХАУ ямагт хүндэтгэж ирснийг тэмдэглэхийн хамт, харилцан ашигтай, хамтдаа хожсон хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн болон орон нутгийн харилцааны салбарт хэрэгжүүлэхийг хүсч байгаагаа илэрхийлсэн. Яг энэ үгийг Ерөнхийлөгч Си ирэхдээ мөн хэлж байсан. Том улсын удирдагчид нэг хэлээр ярьж байгаа нь энэ л дээ.

Айлчлалын хүрээнд:

- “Монгол улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийн дагалдах барилга байгууламжийн төсөл”-ийн гэрээ
- Дорноговь аймгийн Замын-Үүд сум болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот хоорондын гэрээ
- Дорноговь аймгийн Сайншанд болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Бугат хотын Дархан мянгад холбоод хошуу хоорондын гэрээнд гарын үсэг зурах ёслол
- Энэ үеэр БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх буудал чиглэлийн хурдны авто замыг ашиглалтад оруулах, Гачууртын уулзвараас Налайх, Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ёслолын самбарын хөшиг нээх ёслол болов.

Монгол улс томоохон баяр наадмын үеэр ихэвчлэн гуравдагч хөршийн төлөөллүүдийг урьдаг байсан нь Ц.Элбэгдорж Ерөнхийлөгчийн үед илүү байсан харагддаг. Гуравдагч хөршийн бодлого, тэдний хөрөнгө оруулалт Монгол улсын хөгжилд чухал үүрэгтэй. Дараагийн наадмын үеэр гуравдагч хөрш орнуудаас төлөөлөгчдийг түлхүү оролцуулахад анхаарах хэрэгтэй гэж харж байна.



НААДМЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Үйл явдлын товч:

Үндэсний баяр наадам болоод дууслаа. Наадмыг зохион байгуулалт, санхүүжилт талаас нь харвал.

Дүгнэлт тайлбар:

Манай улс Үндэсний их баяр наадмын тухай хуультай. Энэ хуулиараа наадам нээх, хаах дэг журам, бөхийн барилдаан, морин уралдаан, нум сум харвааг ангилах, цол зэрэг олгох тухай нарийн заалтууд байдаг.

Төр ард иргэдийнхээ наадмыг зохион байгуулж өгч байгаа болохоос төрийн өөрийнх нь наадам биш юм. Наадмын баярт зориулсан нийт хөрөнгө 2.9 тэрбум төгрөг болсон юм байна. Гэтэл манайх шиг төсөв багатай, боловсрол, эрүүл мэндийн салбар нь үргэлж санхүүжилтээр гачигдаж байдаг оронд ийм хэмжээний мөнгөөр наадам зохион байгуулах нь хэтэрхий үнэтэй тусч байна л даа.



Төрийн үүрэг бол хүний эрх, аюулгүй байдал, хөрөнгийг л хамгаалах. Үндсэн ажлаа хийхгүй баяр наадам зохион байгуулж гүйхийн оронд хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод нь хариуцуулаад өгчихвөл хамаагүй зардал багатай, жинхэнэ бизнесийн утгаар нь хийчихнэ.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР

Монгол улсад мөнгө олох боломжтой хоёрхон салбар л байгаа. Уул уурхай, аялал жуулчлал.

Үйлчилгээний хамгийн өргөн хүрээтэй, маш олон бизнесийг хамардаг зочлолын (hospitality) салбар нь гурван үндсэн хэсгээс бүрддэг. Үүнд буудал (зочид буудал, дэн буудал, жуулчны бааз), хоол ба ундаа (зоогийн газар, кофе шоп, түргэн хоолны газрууд), аялал ба жуулчлал (онгоц, галт тэрэг, автобус, олон улсын үзэсгэлэн, хурал, урлаг соёлын арга хэмжээ гэх мэт аяллын зорилго ба тээврийн хэрэгслэл) ордог. Энэ салбарт бүх бизнес ганцхан зүйлд өрсөлдөн төвлөрдөг, тэр нь “үйлчлүүлэгч”. Уг бизнесийн амжилт нь тодорхой мөнгө, цагаа зарцуулж буй үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, таашаал авч чадсан эсэхээс хамаардаг.

Монголын зочид буудлуудын холбооны мэдээгээр манай улс эдүгээ 1800 орчим зочид буудал, хоноглох байртайгаас 67 нь ямар нэг одны зэрэглэлтэй, тэдний 10 нь орон нутагт байгаа аж. Монголд таван одтой зочид буудал 11 байгаагаас

дөрөв нь гэрчилгээтэй, дөрвөн одтой есөөс тав нь гэрчилгээтэй бол, гурав ба түүнээс цөөн одтой 1768 буудлаас 58 нь гэрчилгээтэй байна. Буудлыг одоор зэрэглэхийг Байгаль орчин аялал жуулчлалын яам хариуцдаг.

БОАЖЯ-ны эхний гурван улирлаар тооцсон статистик мэдээгээр манай улсын зочид буудлуудад 2014 онд 93 мянга (М), 2015 онд 96 М, 2016 онд 92 М зочин буудаллажээ. Зочид буудлын нийт өрөө энэ гурван жилд 5.3 М, 5.6 М, 6 М болсны гурваас дээш одтой зочид буудлын өрөөний эзлэх хувь нь 26, 27, 28 болж, ирсэн зочдын 22, 25, 31 хувьд үйлчилсэн байна. Нийт орлого 21, 20, 19 тэрбум төгрөг болсны 50, 48, 56 хувь нь гурваас дээш одтой буудлуудад ногджээ. Гурваас дээш одтой зочид буудлуудын өрөөний дүүргэлт жилд дунджаар 50 хувь болсон нь зардлаа дөнгөж л нөхөж байна.

Монголд зочид буудлын салбарын хатуу дэд бүтэц бий болсон ч одоо зөөлөн дэд бүтэц буюу үйлчилгээний чанар, захиалгын тогтолцоо,

боловсон хүчний чадвар зэргээ сайжруулж, олон улсын стандартад хүргэх үлдлээ. Гэвч зочид буудлын салбарын хамгийн том сорилт бол зочноо олж авчрах, гадаад дотоодын жуулчдыг ихээр татах явдал юм.

БОАЖЯ-ны мэдээгээр 2016 онд Монгол улсад 471(М) гадаадын зочид (2012 онд 476 М) ирсний 404М нь жуулчин гэж хил дээр мэдүүлжээ. Жуулчдын 231М нь Ази, Номхон далайгаас (Хятад 145М, Солонгос 40М, Япон 20М), 150М нь Европоос (Орос 70М), 20М нь Америкаас, 1М нь Ойрхи Дорнодоос, 0.7М Африкаас иржээ. Аялал жуулчлалын салбарын орлого 2016 онд 312 сая доллар болсон нь өмнөх оноос 11 хувиар өсөв. Нэг жуулчин дунджаар 772 доллар зарцуулсан гэсэн үг. Гэвч энэ орлогыг гаргасан аргачлал нь тодорхой бус.

Монгол улсад нийт 600 гаруй компани аялал жуулчлал эрхлэхээр гэрчилгээн дээрээ бүртгүүлсэн ч шинэ журмын дагуу 2016 онд 254 аяллын компани аяллын операторын гэрчилгээ шинээр авсан болон сунгуулсан байна. Энэ компаниуд нийтдээ 21М хүн гадаадад явуулж, 53М жуулчин гадаадаас хүлээж авчээ. Энэ компаниудад тогтмол 1168 хүн, харин түр ажилладаг жолооч, орчуулагч, аяллын хөтөч, тогооч нараа оруулаад 3685 хүн ажилласан гэж Монголын Аялал Жуулчлалын Холбоо мэдээллэв.

Нийт жуулчдын зөвхөн 13 хувь нь эдгээр тур оператороор дамжсан нь дийлэнх жуулчид бие дааж ирдэгийг харуулж байна.

Монгол улсын аялал жуулчлалын сурталчилгааны нэгдсэн бодлого, зорилго байхгүй, зорилтот зах



зээлээ одоо болтол сонгоогүй, стратеги, бренд бүтээгдэхүүн, үзмэрүүдээ тодорхойлж чадаагүй, гадаад сурталчилгааны төсөв байхгүй, дотоод нислэг олддоггүй, урьдчилан төлөвлөх ямар ч боломжгүй зэргээс манайд аялал жуулчлал хөгжиж чадахгүй байна. Агаарын тээврээ нээлттэй болгохгүйгээр зочид буудлууд ч удалгүй дампуурах болно. Жуулчдын тоо өнөөгийн түвшинд байх юм бол таван одтой буудлын хэрэгцээг дан ганц Шангрила хангачих юм. Аялал жуулчлалын салбарт ажиллаж буй жараад мянган хүн ажилгүй болно.

Угтаа аялал жуулчлалын салбар бол Монгол улсын эдийн засгийг бараг дангаараа аваад явчих чадавхитай. Төр засгаас жуулчдын аюулгүй байдал, түүний дотор хүнсний аюулгүй байдлыг хангаад, буудал, бааз, үйлчилгээний стандартыг тогтоогоод, гол нь бүрэн сахиулж чадвал агаарын тээврээ либералчлаад, нийслэл хотын замын гацааг арилгачихвал үлдсэнийг нь хувийн салбар шударга өрсөлдөөнөөр аваад явах нь дамжиггүй.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх
боломжтой.*

GOOGLE STORE



APP STORE



Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn
www.jargaldefacto.com